



БАТЛАВ.
ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.ТУНГАЛАГТАМИР

СУЛ ХАРААНЫ СЕРТИФИКАТЫН СУРГАЛТ
СУЛ ХАРААНЫ СУРГАЛТЫН II ХЭСЭГ: СУЛ ХАРААНЫ ЭМНЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭ БА
ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

“L3605/G9191-MON48076:Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” ийн хүрээнд 2020-2021 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв (Цаашид Хөгжлийн төв гэх)-ийг төслийн 6 аймагт байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнд Архангай, Дархан, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймгууд багтаж байгаа ба эдгээр аймгуудын хүн ам 45000-130000 хооронд байна.

Хөгжлийн төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрсэн хүн болон тэдний гэр бүлийг дасгалжуулах, дадлагажуулах, хөгжүүлэх түүнчлэн лавлагаа төвүүдтэй холбон зуучлах, кейс менежментийн тусламжтай хянах, арга зүй, мэдээллээр хангах нийгмийн төв байх юм.

Төвийн зорилго:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насанд нь тохирсон хөгжлийн үйлчилгээ үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийн нийгмийн оролцоонд нь учирч буй саад бэрхшээлийг үнэлэн тогтоох,
- Үнэлгээний үр дүнд үндэслэн тэдний алдагдсан боломж чадварыг сэргээх төрөл бүрийн сургалт үйлчилгээ болон туслах хэрэгслийн тусламжтайгаар боломжит дээд түвшинд хүргэх
- Улмаар өрх бүлдээ төдийгүй олон талт нийгмийн харилцаанд бие даан оролцохыг нь дэмжсэн сургалт үйлчилгээг явуулах, энэ талаар шаардлагатай мэргэжил арга зүйн зөвлөгөө өгдөг байх; Төвийн хүний нөөц дээр дурдсан бүх ажлыг гүйцэтгэх боломжгүй тул бэрхшээлийн төрөл хэлбэр насны онцлог зэргийг харгалзан тухайн чиглэлд мэргэшсэн байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлдэг байх.
- Хөгжлийн төвийн үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, нийгмийн оролцоог гэр орон, хамт олон, нийгмийн орчинд нь сайжруулах, хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Харааны бэрхшээлтэй хүмүүст нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийгдэх, жор бичих болон хараагүй, сул хараатай хүн олон төрлийн туслах багаж төхөөрөмжүүдээр хангагдах шаардлагатай. Харааны бэрхшээлтэй хүүхдэд өдөр тутмын үйл ажиллагаа, хөдөлгөөн, орон зайн баримжаа олох, харилцах болон тоглох чадвар, сургууль цэцэрлэгт бэлтгэх зэрэг хөгжүүлэх үйлчилгээ хэрэгтэй ба олон төрлийн хавсарсан бэрхшээлтэй (тархины саа, сонсголын бэрхшээлтэй гм) бол лавлагаа төвүүдтэй холбон

зуучлах, хянах шаардлагатай. Насанд хүрэгчдэд сэтгэц нийгмийн дэмжлэг шаардлагатай ба үүнд орон зай, хөдөлгөөний чиг баримжаа, өдөр тутмын үйл ажиллагааны чадвар, бие даан амьдрах бусад чадварууд, Брайл үсэг, туслах бүтээгдэхүүнүүдийг хэрэглэж сурах зэрэг болно.

Харааны бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгчид, тусгай сургуульд ажиллах сул харааны мэргэжилтэй байхгүй байна. Нүдний эмч нар нүдний өвчний эмнэлгийн болон мэс заслын тусламж үйлчилгээнд илүүтэй анхаардаг ба харин сул харааны үнэлгээ хийх, туслах бүтээгдэхүүний хэрэглээ, сургалт хийх талаар сурч бэлтгэгдээгүй байдаг. Хөгжлийн төвийн олон мэргэжлийн багтай хамтран ажиллах бэлтгэгдсэн нүдний эмч (хараа зүйч) нарыг сул харааны сургалтын хөтөлбөрөөр сургаж бэлтгэнэ.

ХОЁР. ЗОРИЛГО

Энэхүү сертификатын сургалт нь нүдний эмч нарт зориулагдсан бөгөөд аймагт ажиллаж буй нүдний эмчийн хувьд сул хараатай хүүхэд, насанд хүрэгчдэд эрт үеийн дэмжлэг үзүүлэх, туслах бүтээгдэхүүнийг зөв сонгох, нийгэмд бие даан амьдрахад нь туслах, дэмжих, түүнчлэн хугарал болон сохролыг сул хараанаас ялгаж сурах зорилготой.

ГУРАВ. СУРГАЛТЫН ҮР ДҮН

Энэ сургалтыг дүүргэснээр дараах зүйлсийг сурсан байна:

1. Харааны эмгэг, сул хараа, сохролын ангилал
2. Харааны эмгэгт хүргэх хамгийн түгээмэл шалтгаан
3. Хүүхдийн өсөлтөд сул харааны сэтгэц, нийгмийн оролцоонд үзүүлэх нөлөө
4. Үлдэц харааны үйл ажиллагааг үнэлэх
5. Харааны эмгэг, сул хараа, сохрох зэрэг нийтлэг шалтгаануудын үед авах үндсэн тусламж үйлчилгээ
6. Сул хараатай өвчтөнд өгөх зөвлөгөө
7. Шаардлагатай үед үйлчлүүлэгчид тохирсон лавлагаа шатлал руу илгээх
8. Сул харааны тусламж үйлчилгээний төлөвлөгөө

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- ХНХЯ, АХБ-ны “L3605/G9191:MON-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төсөл
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв (ХБХ-СЗХТ)
- “Эм си ди эс консалтанси” зөвлөх үйлчилгээний компани

Дэмжигч байгууллага: Монголын нүдний эмч нарын нийгэмлэг, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо (МХҮХ)

ТАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн 6 аймагт нүдний эмчээр ажилладаг болон сул харааны төвийг байгуулж хөгжүүлэх боломжтой УБ хотын эмч нар хамрагдана. Хөгжлийн төвтэй хамтран ажиллах лавлагаа байгууллагууд, МХҮХ-тэй хамтран ажиллахын ач холбогдлын талаар мэдээлэл өгнө.

Оролцогчдын тоо: 12 (дээд тал нь)

Тэмдэглэл: зарим нэг хичээлд ХБХСЗХТ-ийн мэргэжилтнүүд оролцож болно.
Эмнэл зүйн үнэлгээ болон дадлага: багшийн ачаалал болон тоног төхөөрөмжийн хангамжтай уялдан дээд тал нь 12 оролцогч байх ёстой.

Оролцогчдод тавигдах шаардлага:

- Аймгийн эмнэлэгт нүдний эмчээр ажилладаг (нэгдсэн болон бүсийн оношилгоо эмчилгээний төв)
- Сул харааны талаар мэдлэгтэй болох хэрэгтэй гэж ойлгосон

Сургалтад оролцсоны дараах дараах хариуцлагыг хүлээнэ:

1. Аймгийн эмнэлгийн түвшинд сул харааны харааны клиник байгуулах талаар төлөвлөх
2. Хөгжлийн төвийн олон мэргэжлийн багийн болон УБ хотын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах

УБ хотоос оролцогчид аймгийн лавлагаа төвүүдэд дэмжлэг, зөвлөгөө үзүүлэх, сул харааны тусламж үйлчилгээг үндэсний түвшинд үзүүлэх талаар төлөвлөх

ЗУРГАА. СУРГАЛТЫН ОНЦЛОГ

6.1. Байршил, хэлбэр, үргэлжлэх хугацаа

Сургалтын нэр	Байршил	Хугацаа
Сул харааны сургалтын II хэсэг: Сул харааны эмнэл зүйн үнэлгээ ба дэмжих үйлчилгээ	- ХБХСЗХТ: 8 өдрийн сургалт болон дадлага хийх - МХҮХ: 1 өдөр- зочилж, сургалт, дадлага хийх	2022.05.24-2022.06.03 Бүтэн 9 өдөр, дадлагын хамт

6.2. Сургалтын хугацаа, багшлах боловсон хүчин

Сургалтын цаг: нийт 63 цаг байх ба үүнээс 24 цаг нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдэд эмнэл зүйн үнэлгээ хийх, 7 цаг нь МХҮХ дээр очиж дадлага хийнэ. Хугацаа: 24.05 – 3.06.2022 (9 өдөр)	Багш: Олон улсын - 1 – Монгол багш – 5 (МХҮХ: 4) Нийт цаг: 61 цаг Монгол багш: 9 цаг Олон улсын багш: 52 цаг [C2 зөвлөхүүд сургалтын эхний болон 9 дэх өдөр болон шаардлагатай үед оролцох болно
---	--

6.3. Оролцогч талуудын салбар дундын уулзалт

Монгол Улсад сул харааны клиник нэн яаралтай байгуулах, стратеги болон түүнд хэрэглэгдэх туслах бүтээгдэхүүн, хүний нөөцийг багтаасан салбар дундын тогтолцоог бий болгох зорилгоор уулзалт зохион байгуулна. Түүнчлэн хүртээмжтэй боловсрол, анхан шатны эрүүл	Оролцогч талууд: ХНХЯ, ЭМЯ, БШУЯ, АШУҮИС, нүдний эмч нарын резиденсийн хөтөлбөр (УГТЭ), Монголын нүдний эмч нарын нийгэмлэг, МХҮХ, ХБХСЗХТ (бусад) Илтгэгч: Dr. May No (олон улсын), Ч.Чимгээ (үндэсний) Дэмжигч: MCDS зөвлөх баг (C2, зорилт 3)
---	--

мэндийн төв, үйлчилгээг хэрхэн дэмжих талаар хэлэлцэнэ.	
---	--

Хугацаа: 2.06.2022

6.4. Заах болон суралцах арга

Сургалт удирдан явуулах багш нь Вьетнам, Хятад, Камбож улсуудад сургалт явуулж байсан ба оролцогчдын мэдлэгийн түвшинд хичээлийн агуулгыг тохируулна. Хичээл интерактив байх ба хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдүүдтэй дадлага хийнэ.

6.5 Сертификат олгох

Хичээлд бүрэн хамрагдсан эсвэл албан ёсны чөлөө авсан тохиолдолд сургалтын дараа сертификат олгоно.

6.6. Сургалтын үнэлгээ

- Сургалтын өмнөх болон дараах сорил авна (хавсралт 1)
- Сургалтын үнэлгээний хуудсыг оролцогчид бөглөнө (хавсралт 2.1)

6.7. Сургалтын агуулгууд

1. Сул харааны сэтгэлзүйд үзүүлэх нөлөөний тухай

Хугацаа: 2 хэсэг: 3 цаг

Багш: Dr. May Ho,

Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Сул харааны тодорхойлолт ба тархалт
2. Сул харааны тусламж үйлчилгээний хамрах цар хүрээ
3. Сул харааны сэтгэл зүйд үзүүлэх нөлөөний тухай

2. Сул харааны үндсэн шалтгаан, шинж тэмдэг

Хугацаа: 2 цаг

Багш: Ч.Чимгээ

Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Сул харааны нийтлэг шалтгаанууд
2. Сул харааны илрэх шинж тэмдгүүд
3. Харааны бэрхшээлд хүргэдэг өвчний үр дагавар

3. LogMAR зарчим, дадлага ажил

Хугацаа: 2 хэсэг: 3 цаг

Багш: Dr. May Ho

Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Харааны өнцгийг үнэлэхэд LogMAR хүснэгтийг ашиглах үндэслэл
2. LogMAR хүснэгтийг зөв ашиглах, үр дүнд дүгнэлт гаргах

4. Сул харааны эмнэл зүйн үнэлгээ

Хугацаа: 3 хэсэг: 6 цаг

Багш: Dr. May Ho

Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Нүдний эмнэл зүйн үзлэг болон сул харааны үнэлгээ хийх зорилгын ялгааг тайлбарлах
2. Сул харааны үнэлгээ хийх үе шатууд, дадлага ажил

- харааны өнцөг, pinhole үнэлгээ, харааны талбай, хугарал, контраст, гялбаа болон бусад сорилууд

- 5. Томруулагчийн хэлбэрүүд, хэмжээг тооцох** Хугацаа: 3 хэсэг: 5 цаг
Багш: Dr. May Ho
Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:
1. Томруулагчийн төрлүүд
 2. Томруулагчийн хэмжээг тооцох, хэрэглэх арга
 3. Resolution хийх чадварыг тодорхойлох
 4. Resolution хийгдэх шаардлагатай зайг урьдчилан таамаглах
 5. Линзний чадлыг хэмжих
 6. Харааны чадлын эквивалент, харах зайн эквивалентыг хэмжих (EVD)
- 6. Сул харааны оптик болон томруулагч багаж** Хугацаа: 2 цаг
Багш: Dr. May Ho
Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:
1. Сул харааны оптик багажийн тухай, оптик бус багажтай харьцуулах
 2. Сул харааны оптик багажийн давуу болон дутагдалтай талууд, хэлбэрүүд, хэрэглэх арга
 3. Сул харааны оптик багажуудыг ялгах, тодорхойлох
- 7. Сул харааны оптик бус багаж** Хугацаа: 2 цаг
Багш: Dr. May Ho
Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:
1. Сул харааны оптик бус багажууд, тэдгээрийн зорилго
 2. Сул харааны оптик бус багажийн ангилал
- 8. Хүүхдийн сул хараа** Хугацаа: 2 хэсэг: 3.5 цаг
Багш: Dr. May Ho
Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:
1. Эмнэл зүйн тохиолдолд суурилан сул хараатай хүүхэдтэй ажиллах онцлог арга барилыг тодорхойлох
- 9. Үлдэц харааны хэрэглээ** Хугацаа: 1.5 цаг
Багш: Dr. May Ho
Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:
1. "Харааны үйл ажиллагааг" тайлбарлах, хэрхэн сайжруулах тухай
 2. "Үлдэц хараа"-г тайлбарлах, өдөр тутмын үйл ажиллагаанд үзүүлэх ач холбогдол
 3. Бие даасан амьдралд хүрэх алхмууд, хүрэх арга замууд
- 10. Харааны үйл ажиллагааны үнэлгээ** Хугацаа: 2 цаг
Багш: Dr. May Ho
Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:
1. Хүүхэд өдөр тутмын үйл ажиллагаанд хараагаа хэрхэн ашиглах, үр дүнг тооцоход харааны үйл ажиллагаа түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох
 2. Багийн гишүүдийн саналыг үндэслэн үр дүнг хэрхэн боловсруулах тухай
 3. Хүүхдийн орчиндоо дасан зохицох чадварыг сайжруулах, эсвэл хараагаа хамгийн сайнаар ашиглахад харааны үйл ажиллагааны дүгнэлтийг хэрхэн ашиглах талаар тайлбарлах

11. Сул харааны клиник байгуулах

Хугацаа: 2 цаг

Багш: Dr. May Ho

Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Сул харааны тусламж үйлчилгээний чухал хэсгийг тодорхойлох
2. Үйлчилгээг төлөвлөх, бий болгоход шаардлагатай стратегиуд
3. Орон нутгийн нөхцөл байдал, үйлчилгээний шатлалын талаар хэлэлцэх

12. Хүүхэдтэй ажиллах дадлага

Хугацаа: 3 өдөр: 24 цаг

Багш: Dr. May Ho

Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Сул хараатай болон хараагүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сул харааны эмнэл зүйн үнэлгээ хийх дадлага ажил
2. Төрөл бүрийн тусламж үйлчилгээг төлөвлөхөд тулгарч буй асуудлуудыг хэлэлцэж, үр дагаврыг авч үзэх.

13. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо дээр очих (МХҮХ)

Багш: МХҮХ (9.00-12.00; 13.00-16.00)

Хугацаа: 7 цаг

Зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Монгол улсад харааны бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй бэрхшээлүүд, ололт амжилт
2. Тусламж үйлчилгээний тухай (хөдөлмөр сургалт, үйлдвэрлэл, кофе шоп, Брайл болон ярьдаг ном, цэцэрлэг)
3. Харааны бэрхшээлтэй хүмүүстэй харилцахад анхаарах зөвлөмжүүд,
4. Орон зайн баримжаа болон хөдөлгөөний чадварын техник болон хэрэгслүүд
5. Харааны бэрхшээлтэй хүнийг чиглүүлэх ур чадварт суралцах дадлага ажил
6. Харааны бэрхшээлтэй хүний хэрэглэдэг туслах бүтээгдэхүүнүүд, технологиуд
7. МХҮХ-ийн хөдөө орон нутаг дахь салбарууд, үйлчлүүлэгчийг илгээх, зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ач холбогдол

ДОЛОО. СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

Зохион байгуулагчид сургалтын тайланг бэлтгэж, сургалт дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор ХНХЯ болон ажлын хэсэгт хүргүүлэх үүрэгтэй.

Сургалтын тайланг дараах иж бүрдэлтэйгээр төсөл хэрэгжүүлэх нэгжид ирүүлнэ.

- Сургалтын талаар товч дүгнэлт
- Сургалтын өмнөх болон дараах сорил, сургалтын үр дүнг үнэлэх үнэлгээний хуудас, түүний үр дүнгийн дүн шинжилгээ, нэгтгэл
- Сургалтад оролцогчдоор гарын үсэг зурж баталгаажуулсан ирцийн бүртгэл
- Багш, туслах ажилтны цагийн тооцоо
- Сургалтын зургууд
- Бусад